



УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН ТАЙЛАНГААС








УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт **60 тэрбум 714.3** сая төгрөгийн зөрчил илрэв.

АУДИТЫН МӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ


Албан шаардлага	Зөвлөмж	Төлбөрийн акт
22 зөрчлийг арилгуулах 60,707.6 сая төгрөгийн албан шаардлага 	2 зөрчлийг арилгуулах зөвлөмж 	6.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх 1 төлбөрийн акт 

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

81.1%	Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 81.1 хувьтай байна. -Тайлант онд хэрэгжиж дуусаагүй дараа он руу шилжсэн: 5 төсөл, арга хэмжээ -Хэрэгжилт дутуу: 10 төсөл, арга хэмжээ
--------------	---

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2023 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

 4 суманд 8ш ундны усны гүний худаг	 730 суудалтай 3 Соёлын төвийн барилгын өргөтгөл
 Нийт 3360 суудалтай 8 сургуулийн өргөтгөл	 Нийт 450 ортой 3 цэцэрлэгийн барилгын их засвар
 Нийт 1650 суудалтай 6 сургуулийн барилгын их засвар	 Нийт 1050 ортой 9 цэцэрлэгийн барилгын өргөтгөл
 200 суудалтай 1 соёлын төвийн их засвар	 330 ортой 4 эмнэлгийн барилгын өргөтгөл
 229 у/м Төмөр бетон гүүр -2	 212.6 метр урттай 5 авто замын ажил
 Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих 2 төсөл, арга хэмжээ	 8 суманд сургууль, цэцэрлэгийн багш нарын компьютер, тоног төхөөрөмж

	122 Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 36, эрх шилжээгүй 14, аймгийн орон нутгийн төсвийн 24, 3 сумын 48 нийт 122 төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулав.
---	---



УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС



ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ, АЖЛЫН ДААЛГАВРЫГ ТӨСӨВ БАТАЛСНААС ХОЙШ БОЛОВСРУУЛЖЭЭ.



Аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний 15.5 хувь нь урсгал шинжтэй арга хэмжээ байна.

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд нийт 2,824.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 71 төсөл арга санхүүжүүлэхээр баталсан бөгөөд 142.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, урсгал шинжтэй арга хэмжээ байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 34, шинээр хэрэгжүүлэх 2 нийт 36 төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуульд бүрэн тусгажээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 7-н Сайдын багцаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оны 212,044.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74,183.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 34 ТАХ, шинээр хэрэгжих 1,498.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг тайлант онд бүрэн хэрэгжиж дуусахаар тооцож баталсан байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 88.4 хувьтай байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих буюу шинээр хэрэгжих 36 ТАХ-ний 2023 оны санхүүжилт 75,232.0 сая төгрөг хийгдэхээс аймгийн Төрийн сангийн дансаар ТАХ-ны гүйцэтгэлд үндэслэн 66,514.1 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 4123.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 23.8 хувь буюу 5 төсөл, арга хэмжээ нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.

Аудитаас Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгөөгүй гүйцэтгэгч нэг бүртэй гэрээг дүгнэж хариуцлага тооцох, барилга байгууламжийг чанартай гүйцэтгүүлж ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлжээ.



УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС



ХХААХҮС-аас эрх шилжсэн, өмнөх оноос шилжих XIII.3.10 хуулийн дугаартай "Малын ногоон тэжээл тариалах төсөл"-ийн хүрээнд 1-р багцаар 345,550.0 мянган төгрөгийн Foton Iovol үр тарианы комбайн худалдан авч 3 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулан 16,000.0 мянган төгрөгөөр түрээсэлсэн хэдий ч төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх байсан боловч 6,691.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.



Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгөөгүй гүйцэтгэгч нэг бүртэй гэрээг дүгнэж хариуцлага тооцох, барилга байгууламжийг чанартай гүйцэтгүүлж ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.



БШУС-аас эрх шилжсэн "Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга"-ын ажлын гүйцэтгэгчээр барилгын ашиглалтын явцад үүссэн эвдрэлийг заслуулах арга хэмжээ авч, биелэлтийг тооцож хариу ирүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.



Улсын комиссын актаар 2023 онд байнгын ашиглалтад хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй 54,850.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүллээ.



УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ:



Нийт 60,714.3 сая төгрөгийн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж



60,707.6 сая төгрөгийн 22 албан шаардлага



2 зөвлөмж



6.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт

Шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний зураг төсөл, техникийн баримт бичгийг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 34, шинээр хэрэгжүүлэх 2 нийт 36 төсөл, арга хэмжээг бүрэн тусгасан байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 88.4 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн ТАХ-ний 23.8 хувь буюу 5 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.

Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж заавар журмын дагуу захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй 3 ТАХ-г улсын комисс хүлээн авсан байна.

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 54,850.5 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 82.5 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 76.9 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Хаяг: Аймгийн ЗДТГ-ын А корпус,
3-н давхар 312 тоот
Утас: 70333141
И-Мэйл: arkhangai@audit.gov.mn